

Даатгалын бүтээгдэхүүний мэдэгдлийн маягт

1	Мэдэгдэл огноо	Он	2021	Сар	03	Өдөр	31
2	Мэдэгдэл гаргагчийн оноосон нэр	БОДЬ ДААТГАЛ ХК					
3	Даатгалын бүтээгдэхүүний нэр	БҮХ ТӨРЛИЙН МЭРГЭЖЛИЙН ХАРИУЦЛАГЫН ДААТГАЛ					
4	Даатгалын бүтээгдэхүүний холбогдох даатгалын хэлбэр	Хариуцлагын даатгал					
5	Даатгалын бүтээгдэхүүнийг борлуулах тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр	Шийдвэрийн нэр		Огноо		Дугаар	
		Даатгалын бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулах тухай		2021.03.31		ТУЗ/2107	
6	Цахимаар борлуулах эсэх	<input checked="" type="checkbox"/> Тийм <input checked="" type="checkbox"/> Үгүй					
7	Даатгалын хураамжийг тооцоолсон актуарч:	Овог		Нэр			
		Балсан		Баярмагнай			
Мэдээллийн төрлийг сонгоно уу.							
8	Даатгалын бүтээгдэхүүнийг шинээр борлуулах <input checked="" type="checkbox"/> Даатгалын бүтээгдэхүүнийг шинэчлэх						
Даатгалын бүтээгдэхүүний ерөнхий мэдээлэл							
9	Даатгалын зүйл	Даатгуулагчийн санамсаргүй болгоомжгүй үйлдэл, эс үйлдэхүйн улмаас үйлчлүүлэгч, захиалагч, гуравдагч этгээдэд дараах байдлаар учруулсан хохиролд хүлээх хариуцлага: <input type="checkbox"/> Гуравдагч этгээдийн амь нас, эрүүл мэнд, бие эрхтний гэмтэл, нас баралт <input type="checkbox"/> Гуравдагч этгээдийн эд хөрөнгийн эвдрэл ба хохирол хариуцлага					
	Даатгалын үндсэн эрсдэл	- Даатгуулагч мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх явцад болгоомжгүйгээр алдаа гаргах - Даатгуулагчийн даатгагдсан ажиллагсдын ажил мэргэжлийн алдаа, санамсар болгоомжгүй үйлдлийн улмаас ажилдаа гаргасан алдаа					

Даатгалын нэмэлт эрсдэл	Дараах нэмэлт хамгаалалтууд багтана: Үйлчлүүлэгчийн гаргасан шүүхийн зардал, улсын тэмдэгтийн хураамж /.....₮ хүртэл/ Хохирлын үнэлгээний хөлс /.....₮ хүртэл/
Даатгалын хураамжийн хувь, хэмжээ	0.08 -3.0 хувь

ДААТГАЛД ХАМРАГДАХГҮЙ НӨХЦӨЛ

1. Даатгалын тухай хуулийн 8.5-д заасан үндэслэл бүрдсэн;
2. Урьдчилан таамаглаагүй бизнесийн саатал, ашгийн алдагдал, үр дагавраас үүдэн гарах хохирол, санхүүгийн алдагдал, даатгалын гэрээгээр даатгалын хамгаалалтад хамруулахаар зааснаас бусад тохиолдолд үйлчлүүлэгчийн хүлээсэн алдагдал, олох байсан орлого;
3. Даатгуулсан ажилтан эрхэлж буй мэргэжлийн үйл ажиллагааг явуулах эрхгүй, мэргэжлийн зэрэггүй, сургалтанд хамрагдаагүй, мэргэжлийн үнэмлэхгүй үедээ гуравдагч этгээдэд учирсан хохирол.
4. Гэрээнд заагдаагүй эрсдэл, даатгагдаагүй үйл ажиллагаа, үндсэн нөхцөлд тусгагдсан ажил мэргэжлээс бусад үйл ажиллагаа явуулж байхад учирсан хохирол.
5. Даатгуулагч ажиллагсдын хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны нөхцөл орчныг бүрдүүлээгүй, аюулгүй ажиллагааны журам дүрмийг шууд ноцтой зөрчсөнөөс гуравдагч этгээдэд учирсан хохирол;
6. Хохирол учирсан талаар эрх бүхий байгууллага, даатгагчид нэн дариу мэдэгдэн шалгуулаагүй болон бусад шалтгаанаар даатгалын зүйлд хохирол учирсан шалтгаан тогтоогдоогүй, тодорхой бус байх;
7. Нөхөн төлбөрийн баримтуудыг хүлээлгэж өгөх, нөхөн төлбөрийн нэхэмжлэлийн хүлээлгийн хугацаа дуусгавар болсноос хойш нөхөн төлбөрийн нэхэмжлэл хүргүүлсэн;
8. Сайн дураар төлсөн болон хүлээн зөвшөөрсөн төлбөр, хохирол, санхүүгийн алдагдал ба түүний үр дагавраас үүдэлтэй хохирол
9. Торгууль, шийтгэвэр, төрийн байгууллагаас ногдуулсан шийтгэвэр;
10. Тухайн мэргэжлийн холбогдолтой дотоодын хууль дүрэм, мэргэжлийн ёс зүйг санаатай, ноцтой зөрчсөний улмаас үүдсэн хохирол
11. Даатгуулагчийн ажилтан согтууруулах, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэсэний улмаас учирсан хохирол ба гэмт хэргийн шинж чанартай аливаа хохирол;
12. Даатгуулсан ажилтны бие болон сэтгэл зүйн өвчин эмгэгээс шалтгаалж гуравдагч этгээдэд учирсан хохирол.
13. Үйлчлүүлэгчийн гаргасан нэхэмжлэлийг шийдвэрлэх шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд даатгагчийг оролцох боломжоор хангаагүй;
14. Шалган турших, судалгаа, шинжилгээний ажлын явцад учирсан хохирол;
15. Даатгуулагч нь эрх бүхий байгууллага болон даатгагчийн шаардлага, сануулгыг биелүүлээгүйгээс учирсан хохирол;
16. Бүх төрлийн тээвэрлэлт, тээврийн хэрэгслийн ашиглалттай холбоотой учирсан хохирол
17. Даатгуулагч байгууллагын хувьцаа эзэмшигч, ажилтан, итгэмжлэн хариуцаж буй эд хөрөнгөд учирсан хохирол;
18. Даатгагдсан ажилтан хөдөлмөрийн гэрээнд заагдаагүй ажил үүрэг гүйцэтгэх, ээлжийн болон ажлын бус цагаар ажил гүйцэтгэсэнээс учирсан хохирол, гэрээнд заасан үйл ажиллагаатай холбоогүй ажил үйлчилгээ эрхэлсэнээс учирсан хохирол;
19. Аливаа барилгын зураг төсөл, архитектор, дизайны ажилтай холбоотой аливаа хохирол
20. Гуравдагч этгээд, үйлчлүүлэгчийн нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, сэтгэл санаанд учирсан хохирол;
21. Монгол улсын нутаг дэвсгэрээс гадна явуулсан үйл ажиллагаанаас учирсан хохирол;

22. Дайн, дайн бүхий байдал, зэвсэгт бослого, байлдааны зэвсэг хэрэглэх, үймээн самуун, террорист үйл ажиллагаа, бослого, ажил хаялт, төрийн захиргааны байгууллагын акт шийдвэр, улс төрийн тэмцэлд оролцсон, цөмийн дэлбэрэлт, цацраг идэвхт бодис буюу туяаны хордлого;
23. Хууль тогтоомжинд заасан бусад үндэслэлүүдээр даатгагч тус тус даатгалын нөхөн төлбөр олгох үүрэг хүлээхгүй.